

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
Г.ЦЭРЭНДУЛАМЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Гүйцэтгэлийн түвшин			
				Хүрэх түвшин	Хүрсэн түвшин /Биелэлт/	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6		
НЭГ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ТӨРИЙН УДИРДЛАГА							
1	Арга хэмжээ №1.1. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал	“Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал	2023 оны хяналт шинжилгээ, үнэлгээний дүн	2024 оны хамаарал бүхий зорилт, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.	Хужирт-Бат-Өлзий сумын асфальтан зам тавих тендер зарлагдаж, “Мотор сервис”, “Өндөр сант хайрхан” ХХК-ууд гүйцэтгэхээр шалгарч 2022 оны 09 дүгээр сард замын ажил эхэлж 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Дээд өргөн чөлөөний 900 м асфальтан авто замын ажлыг “Андрарөүд” ХХК гүйцэтгэж байна. Ажлын явц 90 хувьтай. Улаан-Амны бага сургуулийг түшиглэн хүүхдийн “Хөдөлмөр зуслан”-г 2024 онд туршилтаар ажиллуулсан. 2024 онд Могой, Мойлтын зам, Өвтийн Мөстийн зам засварын ажлыг “Их сумт хайрхан” ХХК гүйцэтгэсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 82,0 сая төгрөгөөр 80 морины хүчин чадалтай трактор дагалдах эд анги анжис, борной, төмс үрлэгч зэргийг авч ашиглаж байна. Билүүт, Онгоцот, Баруун сөдтийн атаршсан 200 га талбайг эргэлтэд оруулахаар хэмжилт хийн эзэнжүүлэн олгосон. Үүнээс 53 га	2024.01.01 2024.12.31	

					талбайд малын тэжээл тарьсан. 180 сая төгрөгийн өртөгтэй мал нядалгааны цэг байгуулах шийдвэр гарч тендер зарлан “Шоо констракшн” ХХК шалгаран Газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай гэрээ байгуулсан. Тус компани нь мал нядалгааны цэгийг барьж тоног төхөөрөмжийг суурилуулж дууссан. Сумын хэмжээнд цэцэрлэгт хүрээлэнгийн талбай 4, зам дагуух ногоон зурвас 2, бичил цэцэрлэгт хүрээлэн 1 байгуулагдсан. Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах тухай” 2024 оны А/76 дугаар захирамжийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 25-27-ны хооронд хаврын бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан. Нийт 2 удаагийн хог тархсан талбайг хумьж, отволдсон. 240000 м2 талбайн хог хаягдлыг цэвэрлэн 2654 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт буулгасан. Сэг зэмийн устгалын ажлаар бодын сэг 601, богийн сэг 1565, нийт 2166 малын сэг зэм цэвэрлэн тээвэрлэж, булж устгасан. ТӨҮГазар хогийн цэг дээр хог шатаах зуух байршуулсан.		
2	Арга хэмжээ №1.2. “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолд заасны дагуу хотоос хөдөө рүү	Хотоос тухайн суманд ирж суурьшсан иргэдийн тоо	Хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа иргэн, өрх, хөдөлмөр эрхлэгч, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогоор	Суманд Улаанбаатар болон бусад аймаг орон нутгаас 2024 онд 29 иргэн шилжиж ирсэн. 2024 онд “Хүрхрэн чимэг” хоршоо байгуулагдан сав баглаа боодлыг шинэлэг байдлаар шийдэн цайны эзэгий, борцтой хийцтэй цайг тус бүр 1000 ширхгийг хийж борлуулаад байна. Бүтээгдэхүүний хийх цагаан идээг 15 малчин өрхөөс авахаас гадна байнгын 1	2024.01.01 2024.12.31		

	шилжин суурьшиж байгаа иргэн, өрх, хөдөлмөр эрхлэгч, орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломжийг бүрдүүлэх бодлого баримталж ажиллаж, “Нээлттэй Өвөрхангай хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, орон нутагт хөрөнгө оруулалт татах, сурталчлах чиглэлээр хамтран ажиллах			дэмжиж ажилласан байна	ажлын байр бий болгосон. Шинээр 9 ажлын байр нэмэгдэж, 10 ажлын байрыг хадгалан ажиллаж байна. Энэхүү ажлын байранд УБ хотоос шилжиж ирсэн 3 иргэн ажиллаж байна. Улаанбаатар хотоос 1 эмч, 4 багш, хархорин сумаас багш 3, газрын даамал 1, ногоон байгууламж хариуцсан ажилтан 1 иргэн байна. Шилжин суурьшсан нийт 13 иргэн ажлын байртай болгож нийгмийн баталгааг ханган ажиллаж байна. 30 айлын орон сууц суманд баригдаж байгаа ба ашиглалтад ороход нь иргэдийн бага хувийн хүүтэй ипотекийн зээлд хамруулж урьдчилгаа төлбөрт батлан даалт гаргана.		
ХОЁР. ЦЭРЭГ, БАТЛАН ХАМГААЛАХ							
3	Арга хэмжээ №2.1. Цэргийн насны болон өсвөр насны иргэдийн дунд эх оронч үзэл, хүмүүжил олгоход чиглэсэн 2-оос доошгүй сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээний тоо, оролцох бүрэлдэхүүн	2023 онд арга хэмжээнд хамрагдсан.	Сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо нэмэгдсэн байна	Иргэний андгай өргөх ёслолд 16 нас хүрэн эрх зүйн чадамжит иргэн болж 18 залуу иргэний үнэмлэхээ ёслол төгөлдөр гардан авсан. Батлах хамгаалах тухай хууль, цэргийн албаны тухай хуулиар 2 удаагийн сургалтыг зохион байгуулан 18-25 насны 224 залууг хамруулан хүүхэд, залуучуудад эх оронч үзэлд төлөвшүүлэх, улс орны хөгжилд хувь хүн бүрийн оролцоо чухал гэдгийг ойлгуулж, эх орноороо болон монгол хүн болж төрснөөрөө бахархах бахархлыг төрүүлэх, улс орныхоо тусгаар тогтнолын баталгааг нэмэгдүүлэхэд суралцсан.	2024.01.01 2024.12.31	

4	Арга хэмжээ №2.2. Аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2024” цогцолбор тэмцээнд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг бэлтгэн оролцуулах.	Баг, тамирчдын оролцоогоор	оролцоогүй	Баг тамирчдыг оролцуулсан байна.	Санхүүгийн эх үүсвэр байхгүйн улмаас оролцох боломжгүй байсан.	2024.01.01 2024.12.31	
5	Арга хэмжээ №2.3. Өсвөр болон цэргийн насны залуучуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, өвчин, эмгэгийн талаарх мэдээллийн санг бүрдүүлэх, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах	Үзлэгт хамрагдсан иргэд болон мэдээлийн санд бүрдүүлсэн байдлаар	2023 онд иргэнийг эмчлэн эрүүлжүүлсэн	Үзлэгт иргэдийг 90-ээс доошгүй хувьтай хамруулна.	Цэргийн татлагад 248 залуу хамрагдсан бөгөөд залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан өвчин, эмгэгийн талаар мэдээллийн сан бүрдүүлэн эрүүлжүүлэх ажлыг хийсэн. Үзлэгт хамрагдсан залуучуудад эрүүл мэндийн зөвлөгөө өгч, зөвлөмж тараасан. Цэрэг татлагын үзлэг 94 хувьтай дүгнэгдсэн. Эрүүл мэндийн төвтэй хамтран цэргийн насны залуучуудад БЗДХ-аас урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээлэл өгч 320 залуу хамрагдсан.	2024.01.01 2024.12.31	
6	Арга хэмжээ №2.4. “Өсвөрийн аврагч-2024” аймгийн аварга шалгаруулах тэмцээнд сурагчдыг оролцуулах	Тэмцээнд оролцсон сурагчдын тоогоор		“Өсвөрийн аврагч-2024” тэмцээнд сурагчдыг оролцуулсан байна.	Санхүүгийн эх үүсвэр байхгүйн улмаас оролцох боломжгүй байсан.	2024.01.01 2024.12.31	
ГУРАВ.МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ “ХҮҮХДИЙН ЭРХ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ” 01 АЛБАН ДААЛГАВАР, “ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ГЭР БҮЛ							
7	Арга хэмжээ №3.1. Сумын Хүүхдийн төлөө зөвлөл, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг	Хүүхдийн төлөө зөвлөл, залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн	Өмнөх оны 9 дүгээр сард хүүхдийн төлөө зөвлөл байгуулагдсан.	Хүүхэд, залуучуудруу чиглэсэн 5-аас доошгүй үйл	Сумын хүүхдийн зөвлөл нь нийт 20 хүүхэдтэй, Нэгдүгээрт хүүхэд, mini youth power чуулга уулзалтыг сумандаа зохион байгуулж тулгамдаж буй асуудлаар 300 гаруй сурагч хамрагдаж илтгэх,	2024.01.01 2024.12.31	

	тогтмолжуулах, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжсэн арга хэмжээг зохион байгуулах	үйл ажиллагааг тогтмолжуулж хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжсэн арга хэмжээ зохион байгуулсан байна.	43 хувь .	ажиллагаа зохион байгуулсан байна.	мэтгэлцэх чадвараа дээшлүүлсэн. Өвөрхангай аймгийн 19 сумын төлөөллөөс 190 хүүхдийн "Youth power Өвөрхангай" чуулга уулзалт болж сумын хүүхдийн зөвлөлийн 6 сурагч амжилттай оролцсон. Хүүхдийн дуу хоолойг сонсож "Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй" аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд спортын нөхөрсөг 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, волейболын тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалтын эсрэг "Найз байя" рийл бичлэгийн уралдаанд нийт 5 анги бичлэг ирүүлэн цахимаар иргэдэд хүргэсэн.		
8	Арга хэмжээ №3.2. Сумын хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүл, хүүхдүүдийг илрүүлж, хамгааллын болон хариу арга хэмжээг авч, үйлчилгээг шуурхай үзүүлэх	Хамтарсан багийн гишүүлийг чадавхжуулсан байдал Кейс илрүүлсэн, шийдвэрлэсэн тоо Үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	1 165 9710	Эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүл, хүүхдүүдэд хамгаалах үйлчилгээ үзүүлэх	Хамтарсан баг энэ онд 9 кейс дээр ажиллаж 20 хүүхэд, 17 иргэнд хамгааллын болон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлээд байна. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 31 хүүхдийн судалгааг гарган хяналт тавин урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан, өндөр эрсдэлтэй 1 ээж, 7 хүүхдийг хамгаалах байранд байрлуулан, кейс нээн ажиллаж хамгааллын үйлчилгээг үзүүлэн аюулгүй байдлыг хангаж ажилласан.	2024.01.01 2024.12.31	

9	Арга хэмжээ №3.3. Хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлж, зорилтот өрх, гэр бүл, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг судлан тогтоож, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх	Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдээс хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо	85 хувь	Эрсдэлт нөхцөлд байгаа гэр бүл, хүүхдүүдэд хамгаалах үйлчилгээ үзүүлэх	Өндөр эрсдэлтэй 10 хүүхдэд шуурхай хамгааллын үйлчилгээ үзүүлэн “Чи ганцаараа биш” явуулын үйлчилгээнд хамруулсан. “Үе тэнгийн дээрэлхэлт” сэдэвт сургалтанд 40 бүлгийн 1100 сурагч, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга сургалтанд 75 эцэг, эх асран хамгаалагч тус тус хамрагдсан. Зорилтод бүлгийн 2 хүүхдийг Архангай аймгийн “Тамир хүүхдийн зусланд 7 хоногийн хугацаатай амруулав. Хамтдаа шалгая, хамгаалъя арга хэмжээний хүрээнд хүүхдийг гэрээс цэцэрлэг, сургууль хүрэх замын орчны аюулгүй байдлын үнэлгээ хийж эрсдэлтэй орчин мэдээллийг холбогдох байгууллагад хүргэж, эрсдлийг бууруулж ажилласан. СӨБ, ЕБС-ийн сурагчдын сургуульд ирэх, буцах замын ойр орчны аюулгүй байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Аюулгүйн зураглал”-ыг сурагчдын эцэг эх, асран хамгаалагчид, сурагчдаар зуруулсан. Мөн иргэд, хүүхдүүдэд эрсдэлгүй Өвөрхангай, word3words аппликейшинийг тогтмол ажиллуулыг санал болгож байна.	2024.01.01 2024.12.31	
---	---	---	---------	---	--	----------------------------------	--

10	Арга хэмжээ №3.4. Насанд хүрээгүй хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо буурсан байна	Сургалт явуулсан	Нөлөөллийн сургалт зохион байгуулж хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо буурсан байна.	Өсвөр насны 100 хүүхдийг хамруулан бүлгийн уулзалт хийж охидод татгалзах чадвар, охидын жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх” талаар сургалт зохион байгуулсан. Бэлгийн хүчирхийлэлд өртөх магадлалтай 12 хүүхдийн судалгааг гаргаж эцэг, эх, асран хамгаалагч нарт сануулга, зөвлөгөө мэдээлэл тогтмол өгч байна. Багийн эмч, сэтгэл зүйчээр дамжуулан бэлгийн хүчирхийллийн чиглэлээр ганцаарчилсан болон бүлгийн сургалтыг 2 удаа зохион байгуулан 48 эмэгтэй хүүхдийг хамруулсан.	2024.01.01 2024.12.31	
11	Арга хэмжээ №3.5. Хүүхдийг хөдөлмөрийн мөлжлөгөөс сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт зэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн талаар иргэдэд цахимаар болон цаасаар мэдээлэл түгээж ажилласан байна.	Насанд хүрээгүй иргэнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг мөрдүүлж ажилласан байна.	Насанд хүрээгүй иргэнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг мөрдүүлж ажилласан байна.	Насанд хүрээгүй хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны 19 жагсаалтыг ажил олгогч, худалдаа үйлчилгээ эрхэлдэг ААН болон иргэдэд танилцуулж гарын авлагийн 105 иргэнд тараасан. Бат-Өлзий сумын олон нийтийн цахим сүлжээгээр хүүхдийн хөдөлмөрийн мөлжлөгөөс сэргийлэх мэдээллийг түгээнэ ажиллаж байна. 2024 онд шүүхийн шийдвэрээр албадлагын арга хэмжээ авагдсан 1 хүүхэд байгаа бөгөөд түүний зан үйлд нөлөөлөх 3 удаагийн сургалтанд хамруулан, ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч тогтмол зөвлөгөө өгч хамтран ажиллаж байна. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн чиглэлээр 3 жуулчны бааз, 4 ойн нөхөрлөлд 1 удаагийн	2024.01.01 2024.12.31	

					сургалт, мэдээлэл өгч, хүүхдийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг түгээж ажиллаа.		
12	Арга хэмжээ №3.6. Үндсэний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах, тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв тайлагнах, холбогдох байгууллагад хүргүүлэх	Төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг хангасан байна.	Үндэсний болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах, тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв тайлагнах, холбогдох байгууллагад хүргүүлэх	Тайлан мэдээ хугацаатай албан бичгийн хариуг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлсэн байх	Үндэсний 1, аймгийн 2 нийт 3 хөтөлбөрийг хувийн хэрэг нээн, төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрүүдийн тайланг бүтэн жилээр гаргаж Засаг даргын Тамгын газарт хөтөлбөр хариуцсан мэргэжилтэнд жилийн эцсээр гаргаж өгсөн.	2024.01.01 2024.12.31	
ДӨРӨВ.ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГЫН БАРИМТ, БИЧИГ, ХӨТӨЛБӨР, БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ							
13	Арга хэмжээ №4.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилт биелэлтийг хангаж ажиллах.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээр	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж 1 дүгээр сарын 15-ны дотор батлуулж хэрэгжилтийг хангаж ажилладаг	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хэрэгжүүлэн ажилласан	2024.01.01 2024.12.31	
14	Арга хэмжээ №4.2. Салбарын холбогдох хууль тогтоомж,	Жендерийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль,	Иргэдийг мэдээллээр хангасан байна.	Сүүлийн хагас жилд хүн амын 40 хувьд хүрч ажилласан байна.	Салбарын хууль тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас гаргасан суманд хамаарал бүхий	2024.01.01 2024.12.31	

17	Арга хэмжээ №5.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорил”-ыг жилд 2 удаа авч, үр дүнг тооцож ажиллах	-Сорилд хамрагдсан иргэдийн тоо нэмэгдсэн байх	2023 оны байдлаар 18-55 насны нийт 242 иргэд, албан хаагчдыг Бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамруулсан. Иргэдийн 80-с дээш хувь нь хэвийн, бие бялдрын хөгжил харьцангуй сайн гарч, үлдсэн хөгжлийн түвшин доогуур гарсан иргэдэд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг өгч ажилласан.	Бүх албан байгууллага, аж ахуйн нэгжийг сорилд хамруулсан байх, хамрагдсан иргэдийн тоо 100-с доошгүй байх Хөгжлийн түвшинг ахиулах арга хэмжээ авч ажиллах Спортоор хичээллэх нөхцөлийг хангах	Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилд нийт 380 хүн хамрагдсанаас эрэгтэй-117, эмэгтэй-203 байна. Насны ангилалаар авч үзвэл: 1. 3-5 насны нийт 105 хүүхэд хамрагдсанаас 48 эрэгтэй, 57 эмэгтэй хүүхэд. Үүнээс 76.7%-А үнэлгээтэй, 13.3%-В үнэлгээтэй, 10%-С үнэлгээтэй. 2. Ерөнхий боловсролын сургуулийн 6-8 насны 80 хүүхдийн 40 эрэгтэй, 40 эмэгтэй хүүхэд 50%-А үнэлгээтэй, 25%-В үнэлгээтэй, 25%-С үнэлгээтэй. 3. 12-17 насны нийт 96 хүүхдийн 46 эрэгтэй, 50 эмэгтэй, 20%-А үнэлгээтэй, 25%-В үнэлгээтэй, 35%-С үнэлгээтэй, 20%-D үнэлгээтэй байна. 4. 18-56 насны нийт 77 хүний 11 эрэгтэй, 61 эмэгтэй, 12%-А үнэлгээтэй, 30%-В үнэлгээтэй, 30%-С үнэлгээтэй, 17%-D үнэлгээтэй сорилд хамрагдсан байна. “Эрүүл чийрэг Өвөрхангайчууд-2024” аяны хүрээнд 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 30 хүртэлх хугацаанд өглөө 06:00 цагаас 08:00 цаг хүртэл дасгал зохион байгуулагдсан. Давхардсан тоогоор 1977 хүн хамрагдав.	2024.01.01 2024.12.31	
18	Арга хэмжээ №5.2. Иргэдийн дунд “Миний нутаг сайхан” спортын наадмын анхан шатны	Арга хэмжээнд оролчогдын	2023 онд Бат-Өлзий сумын 6 багийн малчдид,	“Миний нутаг сайхан” арга хэмжээг зохиосон байх	“Миний нутаг сайхан” спортын бага наадмыг 2 удаа 1-6 дугаар багийн иргэдийн дунд Үндэсний бөх, шатар, даам, шагайн харваа,		

	арга хэмжээг зохион байгуулах	тоо нэмэгдсэн байх	иргэдийг хамарсан урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийт 1200 гаруй залуус оролцсон.		үндэсний сурын харваа, теннис, олс таталт, сагсан бөмбөг, волейбол, дартс гэсэн спортын 10 төрлөөр зохион байгуулсан. Үүнд: 18-аас дээш насны 700 гаруй иргэн оролцсон. Аймаг, сумын Засаг даргын ивээл дор 2 жилд 1 удаа “Миний нутаг сайхан” спортын арга хэмжээ зохион байгуулдаг. Манай сумын хувьд 2023 онд зохион байгуулсан бөгөөд дараагийн спортын наадмыг 2025 онд зохион байгуулна.	2024.01.01 2024.12.31	
ЗУРГАА. “Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлт, хүн ам, гэр бүл, хүүхэд залуучууд, жендэрийн тэгш байдлын асуудлаар хөтөлбөр, төсөл боловсруулах, төлөвлөх зохицуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилийг хангах, тайлагнах” зорилтын хүрээнд							
20	Арга хэмжээ №6.1. Жендэрийн салбар дундын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээнд иргэд, олон нийт, зорилтот бүлгийг хамруулах, жендэрийн дэд хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах	Сургалт нөлөөллийн ажлын тоо Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	Сургалт, олон нийтийн сүлжээгээр шторк мэдээлэл хүргэсэн.	Жендерийн үндэсний хорооруу тайланг хүргүүлсэн байна.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Албан байгууллага, аж ахуйн нэгжийн нийт 98 ажилтан, албан хаагч нарт жендерийн талаарх ойлголт, жендерийн эрх тэгш байдлыг хангаж ажиллах талаар мэдээлэл өгсөн.	2024.01.01 2024.12.31	
21	Арга хэмжээ №6.2. Хүүхдийн чуулга уулзалт зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хүүхэд хамгааллын бодлогод зааснаар	Хүүхдийн чуулга уулзалт зохион байгуулж	Нэгдүгээрт хүүхэд, mini youth power чуулга уулзалтыг сумандаа зохион байгуулж тулгамдаж буй	2024.01.01 2024.12.31	

			хүүхдийн чуулга уулзалтыг 2 жил тутам зохион байгуулдаг.	хүүхдийн сонгох элчээ	асуудлаар 300 гаруй сурагч хамрагдаж илтгэх, мэтгэлцэх чадвараа дээшлүүлсэн. Хүүхдийн дуу хоолойг сонсож Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй аяны хүрээнд Спортын нөхөрсөг 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн, волейболын тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Электрон тамхины хэрэглээ, насанд хүрээгүй хүн авто машин, мотоцикль жолоодоход анхаарах асуудлууд, учирч болох эрсдлүүд, үе тэнгийн дээрэлхэлт, донтолтоос урьдчилан сэргийлэх, эрсдлээс өөрийгөө хамгаалъя сургалтыг зохион байгуулан ахлах ангийн 98 сурагч хамрагдсан. Хүүхдийн чуулга уулзалтыг Аймгаас өгсөн нэгдсэн удирдамжийн дагуу зохион байгуулахаар шийдвэрлэж хойшлогдсон болно. 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч байгууллагуудын хүүхэд хамгааллын бодлого, ЕБС-ийн хүүхэд хамгааллын баг, дотуур байрны үйл ажиллагаа, хяналтын камерын хэвийн ажиллагаатай танилцаж заавар зөвлгөө, чиглэл өгч ажилласан.		
--	--	--	---	-----------------------------	--	--	--

22	Арга хэмжээ №6.4. Үндэсний соёлыг хөгжүүлэн иргэдийг соён гэгээрүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх /Угийн бичиг хөтлөх, үндэсний бичгээр бичих, унших чадварыг сайжруулах/	Сонирхогчдын тоо нэмэгдсэн байна.	Өмнөх жилүүдэд угийн бичгийн аян, сургалт нөлөөлийн ажил тогтмол явагдсан.	Үндэсний соёлыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх 4-с доошгүй арга хэмжээ зохион байгуулагдсан байна. Оролцогчдын тоо 100-с доошгүй байна.	“Нэг өрх-Нэг угийн бичиг” аяны хүрээнд “Ургийн хэлхээ, удмын толь” танин мэдэхүйн цэнгээнт уралдааныг дөрвөн төрөлтэй зохион байгуулж, 7 багийн 56 хүн оролцсон. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад монгол ахуй, монгол өв соёл, өв уламжлалыг таниулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилготой “Бидний өссөн монгол ахуй соёл” гар зургийн уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд 8-11-р ангийн 15 сурагч бүтээлээ ирүүлж, шилдэг таван сурагчийг шалгаруулж, шагнаж урамшууллаа. “Үндэсний бичиг үсэг”-ийн баярыг тохиолдуулан зохион байгуулсан “Үсэг, бичиг бидний бахархал” уралдаанд 6 дугаар үеийн сурагчдын дунд “Хичээнгүй бичигтэн” уралдаан зохион байгуулж шалгаруулсан. “Үндэсний бичгийн цагаан толгойн баяр”-ын хүрээнд олон төрөлт тэмцээн зохион байгуулж, ЕБС-ийн анги тус бүрээс “Тэргүүний уншигч сурагч”, “Хичээнгүй бичигтэн сурагч” тус тус шалгаруулсан. Хүмүүн бичигтэн арга хэмжээг тохиолдуулан Төрийн албан хаагчид болон иргэдийг хамруулан үндэсний бичгийн цахим сургалт зохион байгуулсан нийт 33 төрийн албан хаагч, 11 иргэн хамрагдсан мөн төрийн албан хаагчдын дунд үндэсний	2024.01.01 2024.12.31	
----	---	--	---	---	--	----------------------------------	--

					бичгийн “Алтан хонх” танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээн зохион байгуулж эхний 3 байрыг шагнаж урамшуулсан. Аливаа тэмцээн уралдаан болон арга хэмжээний шагнал урамшууллыг үндэсний бичгээр бичиж хэвшсэн.		
23	Арга хэмжээ №6.5. Нийгмийн зорилтот бүлгүүд, хүн ам, өрхийн суурь судалгааг Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнээс авч, тэдгээрт чиглэсэн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, хэрэгжилтийг хангах тайлагнах.	-Арга хэмжээний тоо -Хамрагдсан иргэдийн тоо нэмэгдсэн байх	2023 оны байдлаар сумын хэмжээнд зорилтод бүлэг рүү чиглэсэн 4 арга хэмжээ зохион байгуулсан.	Суурь судалгаанд тулгуурлан зорилтот бүлэг рүү чиглэсэн 2-оос доошгүй үйл ажиллагаа явуулсан байх.	Мод тарих төсөлд хүнсний эрхийн бичгийн 20 иргэн хамрагдаж. Санхүүгийн төсөлд ахмад настан 1, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн хамрагдсан.	2024.01.01 2024.12.31	
ДОЛОО. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
24	Арга хэмжээ № 7.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах.	Ёс зүйн зөрчил гаргахгүй байх.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил гаргаагүй.	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг 100% сахин ажиллах.	Удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаварыг биелүүлж, иргэдтэй, хамт олонтой ёс зүйтэй харьцаж төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээг сахин ажиллаж байна.	2024.01.01 2024.12.31	
25	Арга хэмжээ № 7.2. Төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдлэж, ажлын байр, байгууллагын гаднах орчин, албан үүргээ гүйцэтгэх явцдаа архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх.	Ажлын байр, байгууллагын гаднах орчин, албан үүргээ гүйцэтгэх явцдаа архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх.	Албан байгууллага болон албан томилтоор явахдаа ажлын цагаар архидан согтуурахгүй.	Албан байгууллага болон албан томилтоор явахдаа ажлын цагаар архидан согтуурахгүй байх.	Ажлын байр болон ажил үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа согтууруулах төрлийн ундаа хэрэглэж байгаагүй.	2024.01.01 2024.12.31	

26	Арга хэмжээ № 7.3. Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг чанартай, үр дүнтэй гүйцэтгэн тайлагнах.	Хууль ёсны үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь чанартай биелүүлэх.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь хийж гүйцэтгэсэн.	Удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлнэ.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын цаг тухайд нь биелүүлж байна.	2024.01.01 2024.12.31	
27	Арга хэмжээ № 7.4. Байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд идэвхи санаачилгатай оролцох.	Байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээнд идэвхитэй оролцож амжилт үзүүлсэн байна.	Залуучуудын зохион байгуулсан Төрийн албан хаагчдын нэг өдөр арга хэмжээнд оролцсон.	Байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээнд идэвхитэй оролцох.	Салбарын хүрээнд хэрэгжүүлэх ажлуудын хүрээнд холбогдох байгууллагуудад чиглэл өгч, арга зүйгээр тогтмол ханган ажиллаж байна. Үүний үр дүнд байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлоготой болж, эцэг эхийн зөвлөлүүдийн үйл ажиллагаа эрчимжиж гэр бүл, хүүхэд хамгааллын ажлууд чанартай хийгдэж байна. Байгууллагаас зохион явуулж буй уралдаан тэмцээнд идвэхтэй оролцож байна.	2024.01.01 2024.12.31	
28	Арга хэмжээ № 7.5. Нийгмийн идэвхи санаачилгатай ажиллаж, нийтийн арга хэмжээнд тасралтгүй оролцох.	Нийгмийн идэвх санаачилгатай ажиллаж, олон нийтийг хамарсан тэмцээн уралдаан, үйл ажиллагаанд тасралтгүй оролцох.	“Миний нутаг сайхан” урлагын бага наадамд оролцсон.	Олон нийтийн арга хэмжээ болон уралдаан тэмцээнд идэвхитэй оролцох.	Иргэдийн төлөөлөгчийн хурлаас санаачилсан Архигүй орчин аян, Соёлын төвөөс явуулж буй Нэг ном эрхэм үйлс, Нэг өрх-Нэг угийн бичгийн тэмцээнд оролцсон. Эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан гэр бүлийн спортын тэмцээнд оролцож хүрэл медаль, ЕБС-аас зохион байгуулсан эцэг эхийн тэмцээнээс алтан медаль авсан.	2024.01.01 2024.12.31	
29	Арга хэмжээ № 7.6. Шаардлагатай албан бичиг, тайлан мэдээ явуулах үед ажлын бус цаг, илүү цагаар ажиллах.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр.	Илүү цагаар суух ажил гарах үед сууж ажилласан.	Шаардлагатай үед илүү цагаар ажиллах.	Шаардлагатай үед ажлын бус өдөр, болон илүү цагаар ажилладаг.	2024.01.01 2024.12.31	

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжүүлсэн ажил	Дуусах хугацаа	Биел элтийн хувь
	1	2	3	4	5	6	7
31	Арга хэмжээ №2.1. Ажилаа тайлагнах, илтгэх чадвараа нэмэгдүүлэх.	Ажил тайлагнах, илтгэх чадвараа хөгжүүлсэн байна.	Ажил тайлагнах, илтгэх үедээ сул үг бага ашиглаж ярианы чадвараа хөгжүүлсэн.	Ажил тайлагнах, илтгэх чадвараа нэмэгдүүлсэн байна.	Хамтарсан багийн ажлын төлөвлөгөө, тайланг Иргэдийн төлөөлөгчийн хуралд тайлагнаж байна.	2024.01.01 2024.12.31	
32	Арга хэмжээ №2.2 Компьютерийн хэрэглээний төрөл бүрийн шаардлагатай программ дээр ажиллаж чадвараа нэмэгдүүлэх.	Компьютерийн хэрэглээний төрөл бүрийн шаардлагатай программ дээр ажиллаж чадвараа нэмэгдүүлэх.	Компьютерийн мэдлэгээ дээшлүүлэхээр "Хамтдаа хөгжицгөөе" фэйсбүүк группээс хэрэглээний office программууд дээр хэрхэн ажиллах талаар суралцаж мэдлэгээ дээшлүүлж байна.	Шинээр хэрэглэгдэж байгаа компьютерийн программууд дээр ажиллах анхан шатны мэдлэгтэй болсон байна.	Компьютерийн программ дээр ажиллах чадвараа нэмэгдүүлж байна.	2024.01.01 2024.12.31	

33	Арга хэмжээ № 2.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг албан бичиг боловсруулах үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах.	Албан хэрэг хөтлөлтийн найруулгын зөрчилгүй, стандартыг баримтлан алдаа дутагдалгүй байх.		Албан хэрэг хөтлөлтийн стандартыг баримтлан алдаа дутагдал, зөрчилгүй ажиллах, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	Тайлан мэдээ гаргахад Албан хэрэг хөтлөлтийн 246 дугаар тогтоолыг мөрдлөгө болгон ажиллаж байна.	2024.01.01 2024.12.31	
34	Арга хэмжээ №2.4. Өөрийн хариуцсан “Хамтарсан баг”-ийн мэдээллийн самбар “Бат-Өлзий сумын Хүүхэд хамгааллийн хамтарсан баг, раге хаяг, Засаг даргын Тамгын газрын цахим хуудсанд мэдээллийг шинэчлэн тогтмол мэдээлэл байршуулах олон нийтэд түгээх.	Мэдээллийн самбарт шинэ мэдээллийг цаг тухай бүр байршуулах. Байгууллагын цахим хуудас болон “Тарагт сумын хамтарсан баг” , “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл”, фейсбүүк хуудсанд мэдээлэл байршуулах.	Мэдээллийн самбарт шинэ мэдээллийг цаг тухай бүр байршуулах. Байгууллагын цахим хуудас болон олон нийтийн сүлжээнд мэдээлэл байршуулдаг.	Иргэдийг мэдээллээр хангасан байна	Хамтарсан багийн төлөвлөгөө, тайлан, зар мэдээг ханын самбарт байршуулж иргэдийг мэдээллээр хангана ажиллаж байна. Мөн Хүүхэд хамгааллын хамтарсан багийн цахим хаягаар иргэдэд хэрэгтэй мэдээллийг цаг алдалгүй түгээж байна. Хүүхэд, гэр бүлрүү чиглэсэн 8 арга хэмжээ зохион байгуулсан	2024.01.01 2024.12.31	

35	Арга хэмжээ № 2.5. явуулах. Тухайн сард хийсэн ажлаа илтгэх хуудсаар сар бүрийн 23-ны дотор ЗДТГ-ын даргад тайлагнах	Хийсэн ажлаа тайлагнасан байх		Сар бүр ажлаа үр дүнтэй хийж илтгэх хуудсаар тайлагнасан байх	Сар бүр зохион явуулсан ажлын тайлангаа бичиж байна.	2024.01.01 2024.12.31	
36	Арга хэмжээ № 2.6 Монгол бичгээр уншиж, бичиж сурсан байна.	Уншиж, бичиж сурах	Монгол бичгээр анхан шатны хичээлд суусан.	Монгол бичгээр алдаагүй бичиж, уншиж сурсан байх	Монгол бичгээр уншиж бичих суурийг эзэмшсэн. Мөн онлайнаар монгол бичгийн хичээлд суралцаж байна.	2024.01.01 2024.12.31	

ТАЙЛАН ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН



Г.ЦЭРЭНДУЛАМ